



**“НАЛАЙХЫН ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК” ХК
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2025 оны 02 сарын 23 өдөр

Дугаар А/08

Улаанбаатар хот

**Албан тушаалын тодорхойлолт батлах
тухай**

Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.1 дэх хэсэг, Налайхын үйлдвэрлэл, технологийн парк хаалттай хувьцаат компанийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.6.12 дах заалт, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 04 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Компанийн дотоод хяналт, шинжилгээ үнэлгээ хариуцсан менежерийн албан тушаалын тодорхойлолтыг нэгдүгээр, Ахлах мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг хоёрдугаар, Ахлах нягтлан бодогчийн албан тушаалын тодорхойлолтыг гуравдугаар, ерөнхий инженерийн албан тушаалын тодорхойлолтыг дөрөвдүгээр, цахилгааны инженерийн албан тушаалын тодорхойлолтыг тавдугаар, захиргааны мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг зургаадугаар, хуулийн мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг долоодугаар, төлөвлөлт хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг наймдугаар, хөрөнгө оруулалт хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг есдүгээр, маркетинг хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг аравдугаар, гадаад харилцаа хамтын ажиллагаа хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг арван нэгдүгээр, аж ахуйн няравын албан тушаалын тодорхойлолтыг арван хоёрдугаар, жолоочийн албан тушаалын тодорхойлолтыг арван гуравдугаар, манаач, харуулын албан тушаалын тодорхойлолтыг арван дөрөвдүгээр, үйлчилгээний ажилтны албан тушаалын тодорхойлолтыг арван тавдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Албан тушаалын тодорхойлолт шинэчлэн батлагдсантай холбогдуулан нийт албан хаагч, ажилтантай байгуулах хөдөлмөрийн гэрээг боловсруулан батлуулахыг Захиргааны мэргэжилтэн (Д.Номин-Эрдэнэ), Хуулийн мэргэжилтэн (Б.Болортуяа) нарт үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дотоод хяналт, шинжилгээ үнэлгээ хариуцсан менежер (Д.Ганзориг)-т даалгасугай.

4.Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан газрын даргын 2020 оны “Албан тушаалын тодорхойлолт батлах тухай” А/05 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Ч.РАДНААБАЗАР